



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.2 дахь заалт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 5 дугаар зүйлийг тус тус үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Монгол Улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хорооны 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хамтран зохион байгуулсан “Хуулийн хэрэгжилт, ач холбогдол, цаашдын үр нөлөө” онол практикийн бага хурлаас гарсан үр дүнг үндэслэн хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай:


1/Төсвийн шинэчлэлийн хүрээнд жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийг нэвтрүүлэх, Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогод нарийвчлан тусгах, уялдаа холбоог хангаж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эдийн засаг, хөгжлийн яам (Б.Жавхлан) болон Сангийн яам (Б.Жавхлан)-нд;

2/Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэвтрүүлэх зорилгоор батлагдсан Боловсрол, шинжлэх ухааны салбарт баримтлах жендэрийн тэгш байдлыг хангах бодлогын /2017-2024/ хэрэгжилтийг эрчимжүүлэх, жендэр судлалыг академик түвшинд хөгжүүлэх чиглэлээр ажиллаж буй Жендэрийн үндэсний хорооны дэргэдэх эрдэмтэн судлаачдын бүлгийг Шинжлэх ухаан, технологийн сангаас дэмжих, эрдэм шинжилгээний үйл хэрэгт татан оролцуулах замаар уялдааг хангаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны яам (Л.Энх-Амгалан)-нд.

2. Энэхүү тогтоолын 1 дүгээр хэсэгт заасан үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулж ажиллахыг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (Ц.Нямдорж)-т даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтийг 2023 оны хаврын чуулганаар Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



Ж.МӨНХБАТ